

ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР ҮНЭТЭЙ ҮГ ХЭЛСЭН БҮТЭЭЛ

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, доктор (Dr.Sc.), профессор

Түлхүүр үгс: Орон нутгийн сонин, цахим платформ, хөгжлийн судалгаа, тогтмол хэвлэлийн үр нөлөө, сэтгүүлчийн ур чадвар, контент анализ, түлхүүр ойлголт, чанарын судалгаа

Сүүлийн жилүүдэд Монголын сэтгүүл зүйн судлалд хэд хэдэн шинэлэг хандлага ажиглагдаж байна. Нэг талаар сэтгүүл зүйн түүх, онол, практикийн асуудлуудыг сонирхон судалдаг залуу судлаачдын тоо нэмэгдэж, идэвх санаачилга нь дээшилж байгаа бол нөгөө талаар, тэдний судалгааны сэдвийн хүрээ өргөжиж, урьд өмнө судлагдаж байгаагүй асуудлуудыг сонгон авч, идэвхтэй эрэл хайгуул хийх нь нэмэгдсэн явдал юм. Үүний тод жишээ бол зөвхөн өнгөрсөн хэдэн жилд чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, “Нууц товчоо”-ны нийтлэлийн шинж, хүүхдийн хэвлэл, шог хошин тогтмол хэвлэл, реклам сурталчилгаа, экологийн сэтгүүл зүй, тогтмол хэвлэлийн танин мэдэхүйн асуудал, ярилцлага болон мэдээ зэрэг бичлэгийн зүйл, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, ОНМХ-ийн мэдээллийн эх сурвалж,

эмэгтэйчүүдийн хэвлэл, арилжааны телевизүүдийн хөгжил төлөвшил, МҮОНР-ийн хөгжил, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, сэтгүүлчийн ёс зүй, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн пиар ажиллагаа, эдийн засгийн сэтгүүл зүй, сэтгүүлчийн уран чадварын асуудал, интернэт сэтгүүл зүй, мэдээллийн сайтууд, Монгол Улсын болон ӨМӨЗО-ы ОНМХ-үүдийн харьцуулсан судалгаа, орон нутгийн хэвлэл мэдээллийн судалгаа зэрэг урьд өмнө харьцангуй бага судлагдсан, зарим нь огт судлагдаагүй сэдвээр эрдмийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл бичиж, хамгаалсан явдал юм. Тэдний зарим нь хэвлэгдэн гарч, олны хүртээл болсон нь сайшаалтай бөгөөд дэмжүүштэй эхлэл мөн. Тэдний дотор нэн шинэлэг бөгөөд судалгааны арга зүй, үнэлэлт, дүгнэлтийн хувьд ч, мэдээллийн багтаамжийн хувьд ч анхаарал татахуйц бүтээл бол залуу судлаач, сэтгүүл зүйн доктор Б.Болормаагийн “Монголын шилдэг нийтлэл” цувралын 36 дахь боть болон хэвлэгдсэн “Монголын орон нутгийн хэвлэл мэдээллийн хөгжлийн судалгаа” нэг сэдэвт зохиол юм. Сүүлийн үед “Монголын шилдэг нийтлэл-99”

цувралын ерөнхий редактор, сэтгүүл зүй судлаач, доктор Т.Баасансүрэнгийн санаачилгаар зарим залуу судлаач, сэтгүүлчийн шилдэг бүтээлүүдийг бодлогоор дэмжиж, энэ цувралд оруулан олны хүртээл болгож байгаа нь сэтгүүл зүйн эрдэмтэн судлаачид, уншигчид, ирээдүйн сэтгүүлчдийн талархлыг зүй ёсоор хүлээж байгаа билээ. Өмнө нь энэ цувралаар доктор Д.Сандагсүрэнгийн “Л.Түдэвийн нийтлэлийн онцлог, ур чадвар” /Боть 83, 2021 он/, доктор М.Наранчимэгийн “Монголын нууц товчоо”-г судлахуй” /Боть 98, 2019 он/, доктор Д.Нарантуяагийн “Монголын нийгмийн оюун санааны амьдралд МҮОНТ-ийн үүрэг оролцоо” /Боть 49, 2023 он/ зэрэг бүтээлүүд хэвлэгдсэн бол энэ удаа сэтгүүлч, орчуулагч, судлаач Б.Болормаагийн дээр дурдсан бүтээл олны хүртээл болжээ. Энэ бол сэтгүүл зүй судлаач бидний хувьд чин сэтгэлээсээ дэмжүүштэй эхлэл бөгөөд цаашид “Монголын шилдэг нийтлэл” эрдэм шинжилгээ, судалгааны төв ТББ, МСНЭ хамтран бидэнд олон сайхан бүтээлийг өргөн барина гэдэгт итгэлтэй байна.

Энэ удаа миний бие орон нутгийн сониноор судалгаа хийж, эрдмийн зэрэг хамгаалж байсан хүний хувьд залуу судлаач Б.Болормаагийн “Монголын орон нутгийн хэвлэл мэдээллийн хөгжлийн судалгаа” /2023 он/ нэг сэдэвт бүтээлийг зориуд сонгон авч, санал бодлоо илэрхийлэхийг зорилго болголоо.

Орон нутгийн ОНМХ бол Монголын сэтгүүл зүй судлалд хамгийн бага судлагдсан, цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай сэдвийн нэг мөн. Монгол Улсын хүн амын тал хувь нь амьдардаг орон нутгийн ХМХ-ийг хөгжүүлэх, алдаа

оноог засаж залруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрж хайхад судлаачдын үүрэг асар их гэдэг нь тодорхой. Харамсалтай нь олон жил энэ сэдэв судлаачдын анхаарлын гадна үлдэж байсан юм. Одоогоос 34 жилийн өмнө миний бие орон нутгийн тогтмол хэвлэлийн үр нөлөөг дээшлүүлэх асуудлаар түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалснаас хойш сэтгүүл зүйн докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлийн түвшинд бичигдсэн, орчин үеийн орон нутгийн ОНМХ-ийг түүх, онол, практикийн талаас нь иж бүрэн судлах, хөгжлийн цаашдын чиг хандлагын талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг оролдсон анхны судалгааны бүтээл юм. Нөгөө талаар Монгол Улс нийгмийн ардчилсан тогтолцоонд шилжиж, чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдсанаас хойших орон нутгийн ОНМХ-ийн хөгжил дэвшил, алдаа оноо, тулгамдсан асуудлуудыг цогц байдлаар авч үзэхийг зорилго болгосон бүтээл юм. Чухам үүнд Б.Болормаагийн судалгааны ажлын үнэ цэнэ, онол, практикийн ач холбогдол оршино. Энэ талаар доктор, профессор Т.Баасансүрэн: “Монгол Улсын орон нутгийн хэвлэлийн хөгжлийн онцлог, шинэлэг чиг хандлагыг сэтгүүл зүйн шинжлэлийн үүднээс нягтлан судалж шинжлэх ухаанч гярхай ажиглалт хийж агуулга, ач холбогдлыг нь товойлгон гаргаж тавьсан эрдмийн энэхүү ажлын үнэ цэнэ нэн өндөр юм. Өнгөрсөн... гуч гаруй жилд Монгол Улсад орон нутгийн сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд ээдрээтэй агаад эмзэг төвөгтэй замыг туулж чөлөөт хэвлэлийн хөгжлийн замаар урагшилж явна. Сайн ба саар зүйл, эерэг бөгөөд сөрөг үзэгдлийн аль аль нь бий. Энэ бүхнийг

сэтгүүл зүйн шинжлэлийн үүднээс нэгтгэн судалж, өнөөгийн байдалд нь үнэн зөв дүгнэлт өгч, цаашдын хөгжлийн чиг хандлагынх нь талаар шинэ үг хэлсэнд энэхүү судалгааны бүтээлийн онцгой ач холбогдол оршино” (Б.Болормаа, 2023) гэж дүгнэсэнтэй санал нэг бөгөөд бидний дээрх санааг давхар баталж байна.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн асуудал бол нэлээд нарийн төвөгтэй, хэт өргөн хүрээг хамарсан, судлаачаас багагүй хүч хөдөлмөр, цаг хугацаа шаарддаг сэдэв учир манай залуу судлаачид зориг гарган барьж авч, олон талаас нь судлахаас зайлсхийсээр ирсэн билээ. Харин судлаач Б.Болормаа энэ сэдвийг зориг гарган сонгон авч, нэг сэдэвт бүтээлийн түвшинд судалж, “орон нутгийн хэвлэл мэдээллийн өнөөгийн байдлыг олон талаас нь судлан шинжилж, үнэлэлт өгөн, тулгамдсан асуудал, саад бэрхшээлийг тодорхойлох замаар цаашид хэрхэн хөгжүүлэх талаар бодитой санал дүгнэлт дэвшүүлэхийг зорилго болгосон нь” (Б.Болормаа, 2023) энэхүү судалгааны ажлын шинэлэг тал мөн бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах эхлэлийн тавьж байгаагаараа онцлог юм.

Судлаач манай оронд үйл ажиллагаа явуулж буй 116 ХМХ-ийг судалгааны объект болгон авч, тэдний түүхэн хөгжлийн үүднээс тоймлон гаргахын зэрэгцээ ОрНХМ-ийн агуулга, түүний боловсруулалт, хүлээн авагчдын мэдээллийн хэрэгцээ шаардлага, санал бодлыг судалж, үүнийг орон нутгийн хэвлэл мэдээллийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх асуудалтай холбон тайлбарласан нь оновчтой болжээ. Сүүлийн жилүүдэд

хийгдсэн зарим судалгаа ажиглалт, тоймлох хандлага, хоосон сургаал номлолоос хэтэрч чадахгүй байсантай харьцуулахад доктор Б.Болормаагийн судалгааны ажил нь ОрНХМХ-ийн нийтлэл нэвтрүүлгийн агуулга, бичлэгийн төрөл зүйл, ур чадвар руу нэвтэрч, өөрийн гэсэн санал дүгнэлт дэвшүүлсэн нь сайшаалтай бөгөөд судалгааны ажил нь арга зүйн хувьд зөв, оновчтой болсны илэрхийлэл юм. Энэ бол хэдийгээр төгс биш ч гэсэн томоохон дэвшил гэдгийг хэлэх хэрэгтэй. ОрНХМ-ийн хөгжлийн судалгааны ажлыг удирдан хамгаалуулсан доктор, профессор Д.Дагиймаа “Өнөө цагт хэвлэл мэдээллийн хэрэгслийг дангаар нь судлах хангалтгүй учир хэрэгсэл тус бүрээр шинжилгээ хийхдээ орчин цагийн хэрэглэгчдийн хамгийн өргөн ашиглаж буй нийгмийн сүлжээний хэрэглээтэй хамруулан судалгаа хийсэн юм. ОрНХМ-ийн цахим платформын уялдаа болон тэдгээрийн хэрэглээг судлахын тулд нийт 126 мэдээллийн хэрэгслийн Фейсбүүк хуудас болон 23 мэдээллийн вэбсайтын үйл ажиллагаа идэвхтэй эсэх талаар судалгаа хийн, үр дүнг ашигласан” (Б.Болормаа, 2023) гэсэнтэй санал нэг бөгөөд энэ бол арга зүйн хувьд зөв хандлага гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Судлаач эл бүтээлд “орон нутгийн сэтгүүл зүй” хэмээх ойлголтыг гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын үнэлэлт дүгнэлтэд үндэслэн тодорхойлж, ОрНХМ-ийн үүрэг, онцлог, дүр төрх болон энэ талаарх норматив ойлголтын хүрээг өргөжүүлж, цаашид гүнзгийрүүлэн судлах эхлэлийг тавьсан нь сайшаалтай юм. Мөн орон нутгийн ХМХ-д мэдээллийн шинэ технологи, ялангуяа интернэтийн үзүүлж буй нөлөө зэргээс шалтгаалж

хүлээн авагчдын зан үйл яаж өөрчлөгдөж буйг судалж, энэ хоёр хүчин зүйлийн хоорондох харилцан уялдаа холбоог гарахыг оролдсон нь шинэлэг хандлага мөн. Энэ бүтээлд нэлээд шинэлэг гэж хэлж болохоор сонирхолтой баримт цөөнгүй байгаа нь судлаачийн санаачилга, эрэл хайгуулын үр дүн юм. Тухайлбал, “1920 оноос ОрНХМ-ийн талаар АНУ-д судалж эхэлсэн ба 1920-1940 онд Чикагогийн их сургуулийн профессор Паркийн орон нутгийн сонины судалгаанууд нь сэтгүүл зүйн салбарт анхдагч болон ихээхэн байр суурь эзэлдэг”, судлаач Паркийн “ОрНХМ нь нийгмийн бүх бүлэг давхаргын эрэлт хэрэгцээг хангах, орон нутгийн өнцөг булан бүрд хүрч үйлчлэх ба ардчилсан яриа хэлэлцүүлгийн талбар”, Жановицын “Орон нутгийн түвшинд нийгмийн зохион байгуулалт, засаглалын хяналтыг шүүн хэлэлцэх хэвлэл мэдээлэл юм”, Азид 1960 оны дунд үеэс ОрНХМ-ийг судалж эхэлсэн, Японы судлаач Огава “ОрНХМ бол үзэл бодлоо илэрхийлэх, мэдэх эрхийг хангах төдийгүй олон ургалч, олон талт үзэл бодлыг хөхүүлэн дэмждэг байгууллага” (Б.Болормаа, 2023) гэж тодорхойлсон зэрэг жишээнүүдийг хэлж болно. Хэдийгээр энэ нь давхар баталж нотлохыг шаардах зүйл боловч Монголын судлаачдаас урд өмнө хэн ч өөрийнхөө судалгааны бүтээлд ашиглаж байгаагүй тул шинэлэг юм.

Зохиогч судалгааны өгөгдлийг боловсруулахдаа сүүлийн жилүүдэд өргөнөөр ашиглаж буй компьютерт тулгуурласан чанарын судалгааны программуудыг хэрэглэхийг чухалчилж, КН-coder контент анализын аргыг ашиглан, чанарын судалгааны үр дүнд тулгуурлан өгөгдлийг түлхүүр

ойлголт буюу гол агуулгыг илэрхийлж буй нэгжүүдийн давтамж, тэдгээрийн ерөнхий хэмжээг гаргахын зэрэгцээ түлхүүр үгнүүдийн хоорондох харьцааг Пирсоны корреляцын коэффициент хамаарлыг ашиглан ОрНХМ-ийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг нарийвчлан гарахыг одолдсон нь дэмжүүштэй эхлэл юм. Дээрх аргуудыг Б.Болормаа Монголын сэтгүүл зүйн судалгаанд анх удаа ашигласнаараа онцлог бөгөөд шинэлэг юм. Энэ бол манай сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүдэд үгүйлэгдэж буй арга бөгөөд судлаач үүнийг оновчтой, зөв ашиглаж чадсаныг зориуд тэмдэглэж байна.

Судлаач орон нутгийн ХМХ гэдгийг зөвхөн Монгол Улсад хэвшсэн ойлголтоос арай өргөн хүрээнд авч үзээд, дэлхий дахины сэтгүүл зүйн судлалд яаж, ямар түвшинд авч үзэх талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлж, түүх, онол практикийн бүтээлүүдэд дүн шинжилгээ хийжээ. Өөрөөр хэлбэл, судлаач Монголын орон нутгийн ХМХ-ийн хөгжлийн чиг хандлагыг арай өөр түвшинд авч үзэхийг оролдож, уламжлалт хэвлэл мэдээллийг техник, технологи, цахим платформтой уялдан хөгжүүлэх арга замыг судлан, ОрНХМ-ийн цаашдын хөгжлийн талаар санал зөвлөмж дэвшүүлсэн нь шинэлэг болжээ. Судлаачийн “ОрНХМ-ийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн орчин, эдийн засаг, оролцогч талууд, техник технологийн тааламжтай орчныг бүрдүүлэх.., редакцын хараат байдлаас гарахын тулд ОрНХМ санхүүгийн асуудлаа бие даан шийдвэрлэх шаардлагатай. Үүний тулд мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах, мөн бизнесийн шинэ

загварыг нэвтрүүлэх, хүний нөөцийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд идэвхтэн бичигчдийг татан оролцуулах, сэтгүүлчээр суралцаж буй оюутнуудад тэтгэлэг олгох, бичих сонирхолтой мэргэжлийн бус хүмүүсийг сургах арга замуудыг эрж хайх нь өнөөгийн нөхцөлд хамгийн боломжит гарц гаргалгаа болох юм”

(Б.Болормаа, 2023) гэсэн дүгнэлттэй үндсэндээ санал нэг байна.

Судлаач

Б.Болормаагийн нэг сэдэвт бүтээлд энэ мэтийн ололттой, дэмжүүштэй шинэлэг санаа, үнэлэлт дүгнэлт, практик зөвлөмжийн шинжтэй зүйл цөөнгүй байна. Гэхдээ цаашдын судалгааны ажилд анхаарч үзүүштэй, засаж залруулах зүйл байгааг хэлэх нь зүйтэй юм. ОрНХМ-ийн үүргийн тухай асуудлыг тусгахдаа мэдээлэх буюу орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах үүргийг зугаацуулах, танин мэдүүлэх, хяналтын үүргийн дараа ор нэр төдий оруулсан нь учир дутагдалтай юм. Орон нутгийн иргэдийн тухайн бүс нутгийн талаар мэдээлэл олж авах, түүгээр дамжуулж хяналт тавих, аливаа шинэ зүйлийг танин мэдэх боломж нь зөвхөн мэдээлэх үүргийн

ачаар хэрэгждэг учраас үүнд хайнга хандаж болохгүй. Мэдээлэл түгээгээгүй байхад бусад үүрэг нь хэрэгжих боломжгүй учраас мэдээлэх үүрэг бол ямагт тэргүүн байранд тавигдах учиртай. Энэ бол зөвхөн Монголын сэтгүүл зүйн төдийгүй дэлхийн чөлөөт сэтгүүл зүйтэй орнуудын судлаачид,

ОНМХ-ийн хамгийн түрүүнд баримтлах зарчим юм. Мөн ОрНХМХ-үүд судлаачийн дээр дурдсан үүргүүдийг ямар түвшинд, яаж биелүүлж байгаа талаар баталж нотолсон зүйл дутмаг байна.

Судалгааны ажлын зорилгод нийтлэл, нэвтрүүлгийн боловсруулалт буюу ур чадварын талаар судлах зорилт тавьсан боловч ур чадварын талаар судалсан зүйл бага байна. Тэгсэн мөртлөө сонины уриа, дизайн зэрэг асуудлын талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлжээ. Уг нь ур чадвар уриа, дизайнаас илүү

чухал баймаар. Хэвлэлийн хүрээлэнгийн мониторингийн судалгаанд хэт хөтлөгдөж баруун солгойгүй эш татсан нь учир дутагдалтай юм. Учир нь МХХ мониторингийн судалгаа хийхдээ зөвхөн захидлаар харилцах замаар мэдээлэл цуглуулдаг учраас зарим

«

Судлаачийн “ОрНХМ-ийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн орчин, эдийн засаг, оролцогч талууд, техник технологийн тааламжтай орчныг бүрдүүлэх..., редакцын хараат байдлаас гарахын тулд ОрНХМ санхүүгийн асуудлаа бие даан шийдвэрлэх шаардлагатай. Үүний тулд мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах, мөн бизнесийн шинэ загварыг нэвтрүүлэх, хүний нөөцийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд идэвхтэн бичигчдийг татан оролцуулах, сэтгүүлчээр суралцаж буй оюутнуудад тэтгэлэг олгох, бичих сонирхолтой мэргэжлийн бус хүмүүсийг сургах арга замуудыг эрж хайх нь өнөөгийн нөхцөлд хамгийн боломжит гарц гаргалгаа болох юм” гэсэн дүгнэлттэй үндсэндээ санал нэг байна

»

орон нутгийн ХМХ-ийн редакц асуултад хагас дутуу, ор нэр төдий хариулах тохиолдол элбэг байдаг. Тийм учраас МХХ-ийн мониторингийн судалгааны зарим тоо баримт, дүгнэлт бол учир дутагдалтай гэдгийг анхаарах хэрэгтэй. Гол нь судлаач бүх баримт мэдээллийг зөвхөн өөрийн судалгаанд үндэслэн дүгнэлт хийх ёстой.

Судлаач Японд сургууль төгссөн, гадаад хэлний мэдлэг сайтай учир гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээлүүдийг сайн ашиглаж бүтээлч эрэл хайгуул хийсэн нь сайшаалтай боловч зарим эшлэл нь орчуулгын хувьд учир дутагдалтай, ойлгомж муутай, зарим нь зохих байраа оновчтой олоогүй байна. Мөн хэл найруулга, зөв бичихийн дүрмийн дагуу нэг мөр болгох зүйл, тоо баримтын алдаа ч цөөнгүй байна.

Энэ бүхэн нь сэтгүүл зүйн нэг сэдэвт бүтээлийн үнэ цэнэ, ач холбогдол, хүч хөдөлмөрийг үгүйсгэхгүй бөгөөд дараа дараагийн, мөн энэхүү бүтээлийг улам чанаржуулах, боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай гэдгийг сануулж буй хэрэг юм. Дүгнэж хэлэхэд Б.Болормаагийн “Орон нутгийн хэвлэл мэдээллийн хөгжлийн судалгаа” сэдэвт нэг сэдэвт бүтээл нь өргөн хүрээг хамарсан, нэлээд нарийн төвөгтэй сэдвийн хүрээнд багагүй хүч хөдөлмөр гарган, бүтээлч эрэл хайгуул хийсэн, мэдээллийн багтаамж сайтай, онол, практикийн хувьд шинэлэг бөгөөд ач холбогдолтой, урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй байсан чухал баримт мэдээллийг анх удаа судалгааны эргэлтэд оруулсан үнэлэлт, дүгнэлт сайтай чамбай бүтээл болсныг онцлон тэмдэглэж байна.

Эшлэл

1. Болормаа Б. 2023. Монголын шилдэг нийтлэл. Боть 36 /Орон нутгийн хэвлэл мэдээллийн хөгжлийн судалгаа/. УБ. х.7, 29, 11, 36, 37, 234.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болормаа Б. 2023. Монголын шилдэг нийтлэл. Боть 36. УБ.
2. Болормаа Б., Дагиймаа Д. 2023. Орон нутгийн сонины мэдээллийн агуулгад хийсэн зарим судалгаа. “Сэтгүүл зүй”, №23.
3. Болормаа Б., Дагиймаа Д. 2022. Орон нутгийн хэвлэл мэдээлэл дэх цахим платформын үүрэг. “Сэтгүүл зүй”, №22.
4. Болормаа Б. 2022. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өнөөгийн байдал, хөгжих арга зам. Дижитал эрин дэх салбар дундын судалгаа. ХУИС. 22/4.
5. Зулъякафиль М. 2015. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть I. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
6. Зулъякафиль М. 2018. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть III. Орчин үеийн медиа: шинэчлэл, чиг хандлага. УБ.

Summary

In this article, the author reviews researcher B.Bolormaa's monograph "Examining the Development of Local Media" and analyzes the achievements and shortcomings of this work. This book is a major work published in recent years about the local media in Mongolia, and is unique in its attempt to provide an overview of the historical development, changes and reforms, and challenges of local media in the country and to find solutions to address those challenges. Therefore, the author expresses his views and makes an assessment in the context of the above issues.

Key words: Local newspapers, online platforms, development research, effectiveness of periodicals, journalistic skills, content analysis, key insights, qualitative research.